

**ХАЛХ ГОЛЫН РАЙОНД ЗӨВЛӨЛТ- МОНГОЛЫН  
ЦЭРЭГ ЯПОНЫ ТҮРЭМГИЙЛЭГЧДИЙГ ЯЛСНЫ  
40 ЖИЛИЙН ОЙ**

**(Улаанбаатарт болсон эрдэм шинжилгээний бага хурал)**

МАХН-ын Төв Хорооны дэргэдэх Намын түүхийн институт, МАХН-ын Төв Хорооны дэргэдэх Намын дээд сургууль, БНМАУ-ын Шинжлэх ухааны академи, Монголын Ардын армийн улс төрийн газар, Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтний хорооноос эрхлэн Халх голын районд Зөвлөлт, Монголын цэрэг японы түрэмгийлэгчдийг ялсны 40 жилийн ойд зориулж эрдэм шинжилгээний бага хурал 1979 оны зургаадугаар сард Улаанбаатарт хийлгэв. Тус хуралд МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны гишүүн Намын Төв Хорооны нарийн бичгийн дарга Н. Жагварал, МАХН-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга Г. Адьяа, МАХН-ын Төв Хорооны хэлтсийн эрхлэгч С. Батаа, БНМАУ-ын Шинжлэх ухааны академийн ерөнхийлөгч академич Б. Ширэндэв, БНМАУ-ын Батлан хамгаалах яамны сайд хурандаа генерал Ж. Авхиа, Монгол ардын армийн улс төрийн газрын дарга дэслэгч генерал Д. Ёндондүйчир, Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтний хорооны дарга, армийн генерал БНМАУ-ын баатар Б. Дорж нар оролцов.

Шинжлэх ухааны академийн дэд ерөнхийлөгч академич Ш. Бира тус бага хурлыг нээж хэлсэн үгэндээ: Халх голын районд японы түрэмгийлэгчдийг Зөвлөл, Монголын ах дүү арми хамтран бут цохисны түүхэн ач холбогдлыг тэмдэглэв.

Тус бага хуралд «МАХН-Халх голын байлдааны ялалтыг удирдан зохион байгуулагч мөн», «Японы империалистуудыг Халх голд ниргэсэн ба цэргийн урлагийн хөгжилд түүний үзүүлсэн нөлөө», «Халх голын байлдааны ялалтын түүхэн ач холбогдол», «Монгол, Зөвлөлтийн ах дүү армийн дайчин нөхөрлөл, хамтын ажиллагаа» гэсэн сэдвээр МАХН-ын Төв Хорооны дэргэдэх намын түүхийн институтын орлогч захирал, түүхийн ухааны доктор А. Минис, ЗСБНХУ-ын Батлан хамгаалах яамны цэргийн түүхийн институтын эрдэм шинжилгээний ахлах ажилтан профессор И. С. Глебов, БНМАУ-ын Шинжлэх ухааны академийн түүхийн хүрээлэнгийн захирал академич Ш. Нацагдорж, Монголын ардын армийн улс төрийн газрын дарга дэслэгч генерал Д. Ёндондүйчир нар тус тус илтгэл тавьж хэлэлцүүлээ.

Нөхөр А. Минис илтгэлдээ гучаад оны эцэс, дөчөөд оны эхэн үе бол МАХН, Монголын ард түмнээс хувьсгалын ардчилсан шатны зорилтыг шийдвэрлэж дуусгахын төлөө шаргуу тэмцэл өрнүүлж байсныг тэмдэглэв. Энэ үед дэлхий дахинд фашизм, шинэ дайны аюул илт өсч, капиталист хүрээлэлд оршиж байсан ЗХУ, БНМАУ-ын гадаад байдал түгшүүртэй байлаа.

Империалист түрэмгийлэгчдийн эсрэг нийтийн тэмцэл МАХН-ын баримталж байсан интернационалч байр суурь нь японы түрэмгийлэлд нэрвэгдсэн улс үндэстний тэмцэл, түүний дотор японы дарлалыг эсэргүүцсэн хятадын ард түмний эрх чөлөөний тэмцлийг БНМАУ халуунаар талархан, эв санааны нэгдэлтэй байснаар тодорхойлогдож байлаа.

МАХН эх орноо эрх чөлөө, тусгаар тогтнолыг харийн түрэмгийлэгчдийн аюул заналаас хамгаалах, ЗХУ-тай тогтоосон ах дүүгийн найрамдлаа бататган бэхжүүлэх, улс орны батлан хамгаалах хүч чадлыг зузаатгах талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлсэн юм.

МАХН ах дүү ЗХУ-ын зэвсэгт хүчний улс төр зохион байгуулалт, сурган хүмүүжүүлэх ажлын туршлага дээр түшиглэн Монголын ардын армийн дайчин чадварыг дээшлүүлэн, зохион байгуулалтыг улам боловсронгуй болгох, армийн доторхи намын байгууллагыг бэхжүүлэн, армийн дайчдыг улс төрийн талаар хүмүүжүүлэх, тэдний улс төр, байлдааны бэлтгэлийг дээшлүүлэн цэргийн эрдэмд сургах талаар олон чухал арга хэмжээ авч хэрэгжүүлснийг тодорхой баримтаар дурдав.

БНМАУ-д японы милитаристуудын түрэмгийлэх аюул занал нэмэгдсээр байсан тэр үед улс орны тусгаар тогтнолыг сахин хамгаалах гол баталгаа бол ЗХУ-тай тогтоосон цэрэг улс төрийн холбоо хамтын ажиллагааг улам бэхжүүлж түүний хүчирхэг тусламж дэмжлэгийг авах явдал гэж МАХН үзэж байв. 1936 онд ЗСБНХУ, БНМАУ-ын хооронд байгуулсан харилцан туслалцах тухай протокол гэрээнд ах дүү хоёр орны ард түмэн бие биеэ дэмжин туслах социалист интернационализмын зарчмыг гүн гүнзгий тусгасныг цохон дурдав.

Одоогоос 40 жилийн өмнө японы түрэмгийлэгчдийг бут ниргэсэн зөвлөлт, монголын зэвсэгт хүчний хамтын тэмцлийн түүхэн сургамж нь дэлхийн империалист харгис хүчинтэй улам бүр эвсэн сүлбэлдэж байгаа бээжингийн эрх баригчдын адал балмад бодлого явууллага улам бүр газар авч байгаа өнөө үед онцгой ач холбогдолтой юм гэв.

Профессор И. С. Глебов тус хурал дээр тавьсан илтгэлдээ аугаа их Октябрийн хувьсгалын үр нөлөөгөөр зөвлөлт, монголын ард түмэн түүний зэвсэгт хүчний эвдрэшгүй найрамдал үүсч тогтсоныг цохон дурдав.

Халх голын байлдааны үед японы түрэмгийлэгчдийн эсрэг зөвлөлт, монголын дайчид эрэлхэгээр тулалдаж мөнхийн гавьяа байгуулсан юм гээд 1939 оны наймдугаар сард хийсэн ширүүн тулалдааны үеийн үйл явдлаас дэлгэрэнгүй ярилаа.

Халх голын байлдааны үед цэргийн урлагийн түүхэнд шинэ чухал үйл явдал олон гарлаа. Тэр туршлагаас аугаа их эх орны дайны жилүүдэд ч хэрэглэж байсан юм гээд Халх голын районд японы түрэмгийлэгчдийн эсрэг хийсэн байлдаанд зөвлөлтийн нисэх хүчин, танкийн цэргийн анги нэгтгэлийн гүйцэтгэсэн баатарлаг гавьяаг тодорхой жишээ баримтаар дурдлаа.

Академич Ш. Нацагдорж илтгэлдээ 1939 онд Халх голын районд японы түрэмгийлэгчдийг бут цохиход зөвлөлтийн арми шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн юм гэж онцлон тэмдэглэлээ. 1939 онд японы түрэмгийлэгчдийн эсрэг хийсэн байлдаанд зөвлөлт, монголын армийн дайчдын байгуулсан ялалт нь социалист нийгмийн цэрэг, улс төр, эдийн засгийн хүчин чадал, хүмүүсийн ухамсар үзэл санаа, капиталист нийгмийнхээс хавь үгүй давуутайг илтгэн харуулсан юм. Энэ түүхэн ялалт нь манай орны капиталист бус хөгжлийн замаар хөгжүүлэх нөхцлийг хангаж өгснөөрөө нэн чухал ач холбогдолтой юм гэв.

Нөхөр Д. Ендондүйчир илтгэлдээ: Зөвлөлт, монголын армийн дайчид хүнд бэрх шалгалт сорилтыг даван туулж, ах дүүгийн найрамдал, дайчин нөхөрлөлөө улам бүр зузаатган бэхжүүлж ирлээ. Ялангуяа 1939 онд Халх голын районд японы түрэмгийлэгчдийн эсрэг хийсэн ширүүн байлдааны өдрүүдэд монгол, зөвлөлтийн дайчид мөр зэрэгцэн дайсны эсрэг тулалдаж харийн булаан эзлэгчдэд үхлийн цохилт өгсөн билээ. Энэ байлдааны тэр хүнд хэцүү өдрүүдэд монгол-зөвлөлтийн дайчид дайсны сумнаас бие биеэ хамгаалан харийн дайсныг бут ниргэж баатарлаг гавьяа

байгуулсан юм. Энэ ялалт нь пролетарийн интернационализмын үзэл санааны ялалт мөн гэв.

1939 онд японы түрэмгийлэгчдийг бут цохисон зөвлөлт, монголын армийн энэ түүхэн ялалт нь японы милитарист, олон улсын империалист харгис хүчинд өгсөн томоохон сургамж боллоо. Энэ сургамж нь манай хоёр орны эсрэг аль нэг этгээд халдан довтолбол ямар цохилт хүлээхийг нотлон харуулсан юм гэв.

Тус бага хуралд ЗХУКН-ын Төв Хорооны дэргэдэх марксизм ленинизмын институтын тасгийн эрхлэгч Н. И. Макаров, эрдэм шинжилгээний ахлах ажилтан дэд эрдэмтэн Г. А. Кобалев, ЗХУКН-ын Төв Хорооны дэргэдэх нийгмийн шинжлэх ухааны академийн профессор Н. И. Ганин, ЗСБНХУ-ын Батлан хамгаалах яамны цэргийн түүхийн институтын цэргийн нэвтэрхий толь бичгийн редакцийн ерөнхий эрхлэгчийн орлогч М. В. Новиков, Намын түүхийн институтын тасгийн эрхлэгч дэд эрдэмтэн Д. Даш, эрдэм шинжилгээний ажилтан Х. Маам, Л. Оюунгэрэл, О. Пүрэв, Б. Цэдэн, Намын дээд сургуулийн багш дэд эрдэмтэн П. Дорж, Ш. Лувсандорж, Д. Мягмар, ШУА-ийн түүхийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Ж. Болд, Ч. Дашдаваа, Дорно дахины судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Д. Дүнгэряйчил, Хэл зохиолын хүрээлэнгийн тасгийн эрхлэгч Х. Сампилдэндэв, БНМАУ-ын Батлан хамгаалах яамны ажилтан хошууч генерал Ш. Жадамбаа, Д. Цэдэв болон БНМАУ-ын баатар Л. Дандар, П. Чогдон, хурандаа Р. Рийзэн, Я. Дамдинжав, Б. Товд, «Үнэн» сонины коллегийн гишүүн Д. Чимиддорж нар үг хэллээ.

Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтний хорооны дарга, армийн генерал, БНМАУ-ын баатар Б. Дорж эрдэм шинжилгээний бага хурлын ажиллагааг хааж үг хэлэв.

### **3. Лонжид**